



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/328

Алтай хот

"Хантайшир-100" лого хэрэглэх
журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Оюуны өмчийн тухай хуулийн 6.1, 6.2 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 10, 11 дүгээр тогтоол, 2021 оны 78 дугаар тогтоол, 2022 оны 21 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 22 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийг 2020-2025 онд хөгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийн 1.1 дэх зорилт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4 дэх зорилтыг тус тус хэрэгжүүлэх, Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 21 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн логог нэгдүгээр, лого хэрэглэх журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн лого бүтээх ажлын хөлсөнд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг "Хантайшир аймгийн 100 жилийн түүхэн ой, тохижилт болон бусад зардал"-ын батлагдсан эх үүсвэрээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж, хөрөнгийн зарцуулалтыг тайлагнан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20... оны ...
дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ХАНТАЙШИР УУЛЫН АЙМГИЙН 100 ЖИЛИЙН ОЙН ЛОГО ХЭРЭГЛЭХ ТУХАЙ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл:

1.1.Хантайшир уулын аймгийн 100 жилийн ойн логог хэрэглэхэд энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. 100 жилийн ойн лого, түүнийг үйлдэх, дүрслэх

2.1.Ойн логог зураглал, оёдол, хатгамал, хэвлэмэл хэлбэрээр дүрсэлж хэрэглэж болно.

2.2.Логог үйлдэх, дүрслэхдээ зөвхөн баталсан эх загварын хэмжээ болон тодорхойлолтод заасан өнгийг баримтална.

Гурав. Логог байрлуулах, ашиглах

3.1.Логог дараах байдлаар байрлуулж ашиглана.

3.2.Хуралдаан, уулзалтын танхим, ёслол хүндэтгэлийн зориулалт бүхий өрөө, албан тасалгаанд байрлуулах;

3.3.Ойн үйл ажиллагааны сурталчилгаа, хөтөлбөр, танилцуулга, биеийн тамир, спорт, соёл, урлагийн тэмцээн, өдөрлөг, ойн арга хэмжээ, наадмын бүхий л хэвлэл, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээний үед тухайн арга хэмжээ болж байгаа танхим болон дэлгэц, шторк, аннонс, баннер, тайзанд байрлуулах;

3.4.Урилга, мэндчилгээ, ном, гарын авлага, зурагт хуудас, нэрийн хуудас, энгэрийн болон дурсгалын тэмдэг, үнэмлэх, цахим хуудас, тэмдэглэлийн дэвтэр, хуанли, урамшуулал, бэлэг, дурсгалын зүйл, өргөмжлөл, медаль, цом болон ойн үйл ажиллагааны талаархи мэдээлэл, мэдээ материал, нийтлэл, тайлан, эмхтгэл, судалгааны болон албан хэргийн материал дээр хэвлэх;

Дөрөв. Хяналт тавих

4.1.Энэхүү журмын биелэлтэд тавих хяналтыг аймгийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

4.2.Энэхүү журмыг зөрчиж логог өөр зорилгоор хэрэглэх, дуурайлган үйлдэх, гутаан доромжлох, эх загварыг санаатайгаар гуйвуулан өөрчлөх, архи согтууруулах ундаа, хүнсний зүйл, нийтэд худалдаалах, бараа бүтээгдэхүүн, хувийн компани, ААН-ийн хаяг, хэвлэмэл хуудас, бэлэг дурсгалын зүйлс дээр хэвлэх, дүрслэхийг хориглоно.

4.3.Энэхүү лого нь аймгийн Засаг даргын өмч тул зөвшөөрөлгүйгээр хэрэглэхийг хориглоно.

4.5.Хэрэглэх зөвшөөрлийг аймгийн Засаг даргын Тамгын газраас авна.



